

Аудит хийгдсэн байгууллага:
УРТЫН ГЭГЭЭ ОНӨААТҮГ

**ДОТООД АУДИТЫН НЭГЖ: СҮХБААТАР АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
АУДИТЫН АЛБА**

- ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН -

Аудитын нэр: Гүйцэтгэлийн аудит
Жил: 2020-2021 он

2022 он

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

**АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА: СҮХБААТАР АЙМГИЙН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ АУДИТЫН АЛБА**

**АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: СҮХБААТАР АЙМГИЙН УРТЫН
ГЭГЭЭ ОНӨААТҮГ**

АУДИТЫН ТӨРӨЛ: ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

**АУДИТЫН ХУГАЦАА : 2022.04.28 - 2022.06.22-НЫ ӨДӨР ХҮРТЭЛ АЖЛЫН
28 ХОНОГ**

Аудитын багийн ахлагч : Санхүүгийн хяналт
аудитын албаны даргын үүргийг түр орлон
гүйцэтгэгч Э.Амарбат

Аудитын багийн гишүүн:
Ахлах дотоод аудитор Х.Хүрэлцэцэг
Дотоод аудитор Б.Уянганям

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА
2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ
 - 2.1 Аудитын зорилго
 - 2.2 Аудитын цар хүрээ
3. Байгууллагын сайн туршлага
4. АУДИТЫН ҮР ДҮН
 - 4.1. Илэрсэн асуудлууд
5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. ТАНИЛЦУУЛГА

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын баталсан 01 тоот удирдамжийн дагуу УРТЫН ГЭГЭЭ ОНӨААТҮГ-ын санхүүгийн болон үйл ажиллагаанд дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ.

Сүхбаатар аймгийн Баруун Урт сумын ИТХ Тэргүүлэгчдийн 2018 оны 7 дугаар сарын 23-ний өдрийн 18 тоот тогтоолын дагуу Баруун Урт сумын нийтийн эзэмшлийн зам, гудамж талбайн гэрэлтүүлэг, улсын төсөв, ОНХС болон бусад төсөл хөтөлбөр оруулалтаар хийгдсэн бүтээн байгуулалтын ажлын үр дүнд бий болсон хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээ, түүнд учирч болзошгүй хохирлоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг явуулах чиг үүрэг бүхий 14 хүний орон тоотойгоор байгуулагдсан.

Байгууллагын зорилго:

Хотын иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, гэрэл гэгээгээр тасралтгүй хангах, оршин суугчдын цэвэр цэмцгэр байдал, ая тухтай байдлыг хангах орчин нөхцөлийг бүрдүүлэх гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго:

УРТЫН ГЭГЭЭ ОНӨААТҮГ-ын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудыг үр нөлөөтэй байдлыг үнэлж, дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт:

УРТЫН ГЭГЭЭ ОНӨААТҮГ-ын эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явц, 2019, 2020 онуудын төсөв санхүүгийн үйл ажиллагаа, цалин хөлс олголт, худалдан авах үйл ажиллагаа, санхүүгийн сахилга бат зэргийг хамруулсан.

2.3 Аудитын арга, аргачлал:

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

Дотоод аудитаар байгууллагын удирдлагад дотоод аудитын зорилго, хэрэгжүүлэх зарчмаа танилцуулж, засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны талаар асуулга авсан. Мөн аудитын хамрах хүрээнд багтаасан асуудлуудын хүрээнд байгууллагаас олж авсан мэдээлэл, бичиг баримтад дүн шинжилгээ хийж, түүврийн аргаар сорил хийлээ. Аудитын эдгээр горимын үр дүнд, дотоод аудитын баг хангалттай аудитын нотолгоо цуглуулж аудитын дүгнэлтээ гаргасан болно. Дотоод аудитыг хэрэгжүүлэхэд дараах хууль эрх зүйн баримтуудыг эх үүсвэр болгон ашиглалаа.

- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
- Монгол улсын засгийн газрын 2011 оны 311-р тогтоол
- Сууц өмчлөгчдийн холбооны тухай хууль
- Монгол улсын засгийн газар, төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас баталж гаргасан холбогдох эрх зүйн баримт бичгүүд

3.1 Засаглалын талаар:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 22, 25 дугаар зүйл, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам" –ын дагуу Баруун Урт сумын Засаг дарга нь УРТЫН ГЭГЭЭ ОНӨААТҮГ-ын даргатай контрактын гэрээ байгуулж ажилладаг.

Үйл ажиллагааныхаа үр дүнг Баруун Урт сумын ИТХ-д болон Засаг даргад тайлагнадаг. Байгууллагын засаглалын төлөвшлийг засаглах удирдлагын үүрэг, дотоод аудитын нэгжийн үүрэг, стратеги ба эрсдэлийн удирдлага, ёс зүй ба үнэт зүйлс, хүний нөөц ба хариуцлагын тогтолцоо, хяналт, шинжилгээ, үнэлгээ, гадаад

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

ба дотоод харилцаа, гадаад ба дотоод тайлагнал ба ил тод байдал гэсэн асуудлаар үнэлэхэд 2-р түвшин буюу давтамжтай байна

3.2 Эрсдэлийн удирдлагын талаар:

Эрсдэлийн тухай ойлголт, эрсдэлийн мэдээллийг ашиглах, эрсдэлийг үнэлэх талаар орон нутгийн хэмжээнд засаглах болон гүйцэтгэх удирдлагын ойлголт дутмаг учраас байгууллагын эрсдэлийн удирдлагыг тодорхойлж, үнэлээгүй байна. Иймд эрсдэлийн төлөвшлийг 1-р түвшин буюу эхлэлийн түвшинд байна гэж үнэлсэн.

3.3 Дотоод хяналтын системийн талаар:

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын дагуу дотоод хяналтын нэгжийг байгуулгуулж төлөвлөгөө гаргасан боловч төлөвлөгөөний дагуу ажиллаагүй. Дотоод хяналтын тогтолцооны төлөвшлийг 5 үзүүлэлтээр үнэлэхэд 1-р түвшин буюу эхлэлийн түвшинд байна.

3. АУДИТЫН ҮР ДҮН

Илэрсэн Асуудал 4.1	Дотоод хяналтын нэгж нь үйл ажиллагаа нь тогтмолжоогүй.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал:	Байгууллагын дотоод хяналтын нэгж томилсон, төлөвлөгөө байгаа боловч түүний дагуу үйл ажиллагаа явуулаагүй, тайлангаа удирдлага болон хамт олны хуралд танилцуулаагүй байна.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	ЗГ 2011 оны 311-р тогтоолын "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын дагуу
Асуудлын үндсэн шалтгаан:	<ul style="list-style-type: none">- Албан тушаалтны хуулийн мэдлэг дутмаг- Дотоод хяналтыг хяналт шинжилгээ үнэлгээтэй андуурсан- Үйл ажиллагаандаа дотоод хяналтыг хэрхэн хийж хэрэгжүүлэхээ мэдэхгүй байх
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	Байгууллагын үйл ажиллагаа, ажил үйлчилгээ нь хууль тогтоомж, Засгийн газрын

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

шийдвэр, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны болон өөрийн гаргасан шийдвэрт нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж чадахгүй байх, илэрсэн алдаа зөрчилд гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэж чадахгүй байх, хяналт алдагдах нөлөөтэй.

Зөвлөмж:

ЗГ 2011 оны 311-р тогтоолын дагуу дотоод хяналтыг нэгжийг байгуулан, өөрийн байгууллагын онцлог тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг боловсруулан, төлөвлөгөө гарган ажиллах.

"Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах"-даа дараах чиглэлээр зохион байгуулж болно.

- Үйл ажиллагааны чиглэлээр гарсан тогтоол шийдвэр, захирамжийн баримт бичиг, албан хэргийн шийдвэрлэлт, иргэд аж ахуй албан байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, байгууллагын архив, бусад эрх зүйн бичиг баримтын хэрэгжилтэд

- Ажилтан, албан хаагчийн ажиллах журам болон ёс зүйн дүрмийн хэрэгжилт

- Тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт шалгалт зохион байгуулах

- Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт

- Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, дотоод журмын биелэлт гэх мэт үйл ажиллагаанд хийж болно.

Мөн хийсэн хяналт шалгалтын талаар тайлан бичиж, мэдээллийн сан бүрдүүлэн, эрх бүхий албан тушаалтанд танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулж, хуралд танилцуулна.

Илэрсэн Асуудал 4. 2	Эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал: Ажлын байрны эрсдэл болон бусад эрсдэлд үнэлгээ хийгдээгүй.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: - ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 3 дугаар зүйлийн 3.7.9 байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилт болон зөрчлийн талаарх мэдээллээр удирдлагыг хангах	
Асуудлын үндсэн шалтгаан:	
- Эрсдэлийн үнэлгээний ерөнхий ойлголт, ач холбогдол, үнэлгээ хийх арга	

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

аргачлалын талаар нэгдсэн ойлголт байхгүй.

- Эрсдэлийг зөвхөн шаардлагатай үед тодорхойлдог боловч бүрэн үнэлдэггүй
- Албан тушаалтны хуулийн мэдлэг дутмаг
- Дотоод хяналтын баг ажилладаггүй.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Эрсдэлээ тодорхойлоогүй нөхцөлд байгууллага зорилгодоо хүрэхэд саад бэрхшээл тулгарах, байгууллагын үнэ цэнэ буурна, хэвийн үйл ажиллагаа алдагдах

Зөвлөмж:

Дарга, Дотоод хяналтын ажилтан -д :

Эрсдэлээ тодорхойлон түүнийг удирдаж, бууруулах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

Мэргэжлийн байгууллагаар ажлын байр, эрүүл ахуйн орчинд эрсдэлийн үнэлгээ хийлгүүлж, холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллах.

Илэрсэн Асуудал 4.3	Нягтлан бодогч болон нярав солигдоход эд хөрөнгийн тооллого хийддэггүй.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй

Бодит байдал:

Нягтлан бодогч Д.Дэлгэрсайхан болон Буджав нар нь ажил хүлээлцэхдээ эд хөрөнгийн тооллого хийгээгүй. Ажил хүлээлцэхэд хөрөнгийн жагсаалт гаргаагүй.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

"Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 12.2.2 эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед

Асуудлын үндсэн шалтгаан:

- Нягтлан бодогч ажилдаа хайхрамжгүй хандсан
- Дотоод хяналтын баг ажиллаагүй
- Хяналт сул

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Байгууллагын эд хөрөнгө дутагдах

Зөвлөмж:

Нягтлан бодогч , эд хариуцагч нар өөрчлөгдөхөд комисс томилон тооллого явуулж

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

хэвших, байгууллага дээрээ өмч хамгаалах байгын зөвлөл томилж ажлуулах

Илэрсэн Асуудал 4. 4	Хөрөнгийн эзэмшигч бүрд хөрөнгө эзэмших
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал: Хөрөнгө эзэмших ашиглах карт байхгүй. Хөрөнгө ашиглаж байгаа ажилтанд жагсаалтаар хөрөнгө хүлээлгэж өгөөгүй.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль"-ийн 13 дугаар зүйлийн 13.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна. 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэсэн заалтуудыг Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тогтоол "Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягтыг хөтлөх аргачлал"-ын дагуу хөрөнгө эзэмшигч нэг бүрд карт бөглөж, өөрчлөлт орсон дариуд бичилт хийж баталгаажуулах	
Асуудлын үндсэн шалтгаан: -Нягтлан бодогч ажилдаа хариуцлагагүй хандсан	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Байгууллагын хөрөнгө дутагдах, ашиглалтад хяналт тавих боломжгүй байх	
Зөвлөмж: Байгууллага дээрээ өмч хамгаалах байгын зөвлөл байгуулах, байгууллагын ажилтан нэг бүртэй хөрөнгө эзэмших, ашиглах карт нээж ажиллах	

Илэрсэн Асуудал 4. 5	Авлага өглөгийн тооцоо нийлж баталгаажуулдаггүй.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000**Бодит байдал:**

Авлага, өглөгийн тооцоо нийлж тулган баталгаажуулалт хийсэн баримт байхгүй, гарын үзэг зураагүй, тамга тэмдгээр баталгаажуулаагүй, тооцооны баримтын жагсаалт үйлдээгүй байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тогтоол "Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягтыг хөтлөх аргачлал"-ын дагуу хөрөнгө эзэмшигч нэг бүрд карт бөглөж, өөрчлөлт орсон дариуд бичилт хийж баталгаажуулаагүй.

"Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль" 20 дугаар зүйлийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах гэснийг

Асуудлын үндсэн шалтгаан:

- Дотоод хяналт сул
- Нягтлан бодогч ажилдаа хариуцлагагүй хандсан

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Өр авлагын зохист харьцаа алдагдаж, хяналт хэрэгжүүлээгүйгээс өр авлага нэмэгдэх, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээ гарах эрсдэлтэй байна.

Зөвлөмж:

Өр авлагаа тогтмол Нягтлан бодох бүртгэлийн хууль, стандартын дагуу бүртгэж хэвших, тооцоо нийлсэн хуудас бөглөж хэвших

Илэрсэн Асуудал 4. 6	Шилэн дансны хуулийн хэрэгжилт тааруу
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй

Бодит байдал:

Шилэн дансны цахим хуудаст 2020 онд 40,9 сая төгрөгийн орлого, 40,8 төгрөгийн зардлыг, 2021 онд орлого 409,5 сая, зардлыг 408,9 сая төгрөгийг тус тус мэдээлээгүй байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

"Шилэн дансны хууль"-ийн 6 дугаар зүйлийн 6.4.4. 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр, 6.4.6.худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг мэдээлээгүй байна.

Асуудлын үндсэн шалтгаан:

- Нягтлан бодогч ажилдаа хайхрамжгүй хандсан
- Дотоод хяналтын баг ажиллаагүй

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Мэдээллийн үнэн зөв, ил тод алдагдах

Зөвлөмж:

"Шилэн дансны хууль"-ийг хэрэгжилтийг хангаж ажиллах

Илэрсэн Асуудал 4. 7	Худалдан авах үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулаагүй.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал: 70 сая төгрөгийн үнэ бүхий гэрэлтүүлгийн бараа материалыг тендер зарлалгүйгээр шууд худалдан авсан.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: ➤ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална. Засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 68 дугаар тогтоолын хавсралт, /ТБОНХБАҮХАТХ-ийн 49 дүгээр зүйл /Худалдан авах ажиллагааг тайлагнах/, мөн хуулийн 21.4-т "Захиалагч тендерийн урилгыг энэ хуулийн 52.1.12-т заасан вэб хуудсанд байрлуулж тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ./ мөн Сангийн сайдын 2013 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн 84 дүгээр тушаал-"Цахим хуудаст худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх" журмыг мөрдөж ажиллах	

Асуудлын үндсэн шалтгаан:

- Нягтлан бодогч ажилдаа хайхрамжгүй хандсан
- Дотоод хяналтын баг ажиллаагүй

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх, ашиг сонирхлын зөрчил үүсэх

Зөвлөмж:

Худалдан авах үйл ажиллагааг зохих хуулийн дагуу хийж хэрэгжүүлэх

5.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

- Засгийн газрын 311-р тогтоол "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын дагуу өөрийн үйл ажиллагааны онцлог чиглэлд тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг боловсруулж ажиллах
- Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу шилэн дансыг хөтөлж холбогдох мэдээллийг заасан хугацаанд байршуулан ажиллах, үүнийг дотоод хяналтын баг төлөвлөгөөндөө оруулж тайлагнаж хэвших,
- Худалдан авах үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэйгээр зарлах /ТБОНХБАҮХАТХ-ийн 49 дүгээр зүйл /Худалдан авах ажиллагааг тайлагнах/, мөн хуулийн 21.4-т "Захиалагч тендерийн урилгыг энэ хуулийн 52.1.12-т заасан вэб хуудсанд байрлуулж тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ./ мөн Сангийн сайдын 2013 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн 84 дүгээр тушаал-"Цахим хуудаст худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх" журмыг мөрдөж ажиллах
- Авлага, өглөгийн тооцоо нийлж тулган баталгаажуулалт хийсэн баримтад гарын үсэг зурагдаагүй, тамга тэмдгээр баталгаажуулаагүй, тооцооны баримтын жагсаалт үйлдэх, "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль" 20 дугаар зүйлийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах гэдгийг мөрдөж ажиллах
- Хөрөнгө ашиглаж, эзэмшиж байгаа ажилтан нэг бүрт Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тогтоол "Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

бүртгэлийн маягыг хөтлөх аргачлал"-ын дагуу хөрөнгө эзэмшигч нэг бүрд карт бөглөж, өөрчлөлт орсон дариуд бичилт хийж баталгаажуулах гэсэн зөвлөмжүүдийг хүргүүлж байна.

Уг зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 8 сарын 1-ны өдрийн дотор Санхүүгийн Хяналт Аудитын албанд хүргүүлнэ үү.

Энэхүү дотоод аудитаар илэрсэн асуулын хүрээнд Уртын гэгээ ОНӨААТҮГ-ын үйл ажиллааг "Сайжруулах шаардлагатай" гэсэн дүгнэлт өгч байна.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

АХЛАХ ДОТООД АУДИТОР
ДОТООД АУДИТОР

Ф. Уян

Х. Хүрэлцэцэг
Х.ХҮРЭЛЦЭЦЭГ
Б.УЯНГАНЯМ

ТАНИЛЦСАН:

"УРТЫН ГЭГЭЭ" ОНӨААТҮГ-ЫН ДАРГА



/ Н.ЭНХЖАРГАЛ/